



# БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/337

Булган

## Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд туссан Гурванбулаг сумын сургуулийн дотуур байрны их засварын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2018 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан Улаанбаатар хотын “Баян өндөр булаг” ХХК-тай 105 867 085 /нэг зуун таван сая найман зуун жаран долоо мянга наян тав/ төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг олгосугай.

2. Дээрх ажлын гүйцэтгэгчтэй холбогдох хууль, журмын дагуу гэрээ байгуулж, гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Ү.Бямбасүрэн/- д үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Баян өндөр булаг” ХХК-ийн захирал /Л.Батноров/-д даалгасугай.

4. Энэхүү ажлын санхүүжилтыг холбогдох хууль, журмын дагуу 2018 оны Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /О.Наранжаргал/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ